

Гарчиг

1."Нүүрст хотгор 1-р давхарга" уурхайн талбайн ерөнхий мэдээлэл -----	3
1.1. Товч танилцуулга -----	3
1.1.1. Нөөцийн мэдээлэл-----	4
1.1.2. Төслийн хүчин чадал-----	4
1.2. Физик-Газарзүй, дэд бүтэц -----	5
1.2.1. Газарзүйн байрлал -----	5
1.2.2. Хүн ам, эдийн засаг, зам харилцаа -----	6
1.3. Ордын геологийн тогтоц -----	7
2. Сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт -----	9
2.1 Агаар орчин-----	10
2.2. Усны бохирдол-----	12
2.3. Хөрсний бохирдол, элэгдэл, эвдрэл-----	12
3. Нөхөн сэргээлтийн ажлын биелэлт-----	14
4. Дүүцүүлэн хамгаалах арга хэмжээний биелэлт -----	15
5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ -----	16
6. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт-----	18
7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт -----	19
8. Хог хаягдалын менежментийн төлөвлөгөөний биелэлт -----	21
9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт-----	22
10.Аймаг сумын Засан даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээний биелэлт-----	23
11.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт -----	24
12. Байгаль орчны менежмент төлөвлөө ба түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь. -----	26
Хавсралт -----	27

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Талбайн булангийн солбилцолууд-----	3
Хүснэгт 2. Нөөцийн мэдээлэл-----	4
Хүснэгт 3. Төсөлд ашиглагдаж буй техник тоног төхөөрөмжийн жагсаалт -----	4
Хүснэгт 4. Ажиллах хүчний мэдээлэл -----	5
Хүснэгт 5.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт-----	9
Хүснэгт 6.Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт-----	
Хүснэгт7.Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний биелэлт-----	18
Хүснэгт 8.Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт-----	19
Хүснэгт 9.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт-----	23
Хүснэгт 10.Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт-----	24
Хүснэгт 11 Агаарын чанарын шинжилгээ-----	24
Хүснэгт 12 Хөрсний шинжилгээ-----	25
Хүснэгт 13 Гүний усны шинжилгээ-----	25
Хүснэгт 14 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт-----	26
Хүснэгт 15 Байгаль орчны менежмент төлөвлөө ба түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь-----	29

Зургийн жагсаалт

Зураг 1. Ордын талбайн байршил -----	3
Зураг 2. Нүүрсний ордын газрын доорхи ус-----	6
Зураг 3.Зам, модны усалгаа -----	10
Зураг 4. Хөдөлмөр хамгааллын хувцас -----	11
Зураг 5. Бие засах газар, ариутгалын бодис-----	11
Зураг 6.Талбайд байршуулсан тэмдэглэгээ-----	12
Зураг 7. Урьд болон 2022 онд тарьсан мод-----	14
Зураг 8. Зэрлэг амьтдад хийсэн мониторинг судалгааны ажил-----	15
Зураг 9.Дүйцүүлэн хамгааллын талбайн худаг хүлээлгэн өгч байгаа -----	16
Зураг 10 Хөшөө дурсгал-----	18
Зураг 11Ажилчдыг нормын хувцсаар хангасан байдал-----	19
Зураг 12 Анхны тусламжийн хайрцаг-----	20
Зураг 13 Сургалт зохион байгуулж буй байдал-----	21
Зураг 14 Хог түр ангилан хадгалах цэг-----	23

1. “Нүүрст хотгор 1-р давхарга” талбайн ерөнхий мэдээлэл

1.1. Товч танилцуулга

Увс аймгийн Бөхмөрөн сумын нутагт орших Нүүрст хотгорын нүүрсний ордын талбайгаас “Давхарга-1” нэртэй 29га лицензийн талбайг бүртгэлийн 211001067 тоот гэрчилгээтэй “Рысжан”ХК-д 30 жилийн хугацаатай олгож 2009 оны 04 сарын 03-ний өдрийн ГУУКХ-ийн даргын 39 тоот шийдвэрээр ашиглалтын тусгай зөвшөөрлийг 210001004 тоот гэрчилгээтэй “ЭрчимБаян-Өлгий” ХК-д шилжүүлсэн болно.

“ЭрчимБаян-Өлгий” ХК-ийн эзэмшиж буй MV-005696 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Нүүрст хотгор 1-р давхарга” нэртэй талбай нь Улаанбаатар хотоос баруун тийш 1700 км, Увс аймгийн төв Улаангом сумаас баруун хойш 130 км, Баян-Өлгий аймгийн төв Өлгий хотоос зүүн хойшоо 131 км, Бөхмөрөн сумын төвөөс зүүн хойшоо 60 км, Хотгорын нүүрсний уурхайгаас баруун тийш 7 км-ийн зайд оршдог.

Хүснэгт-1

Талбайн булангийн солбилцолууд		
Булангийн цэгийн дугаар	Цэгийн солбилцол	
	Өргөрөг	Уртраг
1	90° 47' 56, 21 ⁱⁱ	49°49'52, 97 ⁱⁱ
2	90°47'31, 22 ⁱⁱ	49°49'52, 97 ⁱⁱ
3	90°47'31, 22 ⁱⁱ	49°49'11, 77 ⁱⁱ
4	90° 47' 56, 21 ⁱⁱ	49°49'11, 77 ⁱⁱ



Зураг-1 Талбайн байршил

1.1.1. Нөөцийн мэдээлэл

Хүснэгт-2

Нөөцийн мэдээлэл					
№	Нөөцийн зэрэглэл	Блокийн дугаар	Давхаргын эзлэхүүн, мян.м3	Эзлэхүүн жин тн/м3	Нүүрсний нөөц мян.тн
1	Бодит нөөц	В-1	3720.1	1.38	5133.7
2		В-2	2763.2	1.38	3813.2
3		В-3	402.5	1.38	555.5
4		В-4	636.1	1.38	877.2
Нийт			7521.9		10380

1.1.2. Төслийн хүчин чадал

“Эрчим” ХК-ийн нүүрсний уурхайн жилд 70000 тонн нүүрс олборлох хүчин чадалтай. Тус уурхайн Баян-Өлгий аймгийн төвийн Дулааны станц, Өлгий хот, Бөхмөрөн сумын оршин суугч айл өрхүүдийн нүүрсний хэрэглээг хангах зорилгоор нүүрс олборлох, борлуулах үйл ажиллагааг явуулдаг. Тус компани ТЭЗҮ-д заасны дагуу 2022 онд 55000 м3 хөрс хуулж, 55000 тонн нүүрс олборлон борлуулах төлөвлөгөөтэй байна. 2022 онд 990 сая/төгрөгийн борлуулалтын ажил хийж, улсын ба орон нутгийн төсөвт 133,25 сая/төгрөгийн орлого оруулахаар төлөвлөн ажиллаж байна. “Эрчимбаян-өлгий” ХК нь Ашигт малтмалын газрын Нүүрсний хэлтсээр батлуулсан 2022 оны уулын ажлын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулна.

Тус компанийн үйл ажиллагаа 13 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байгаа. Одоогийн байдлаар Техник Эдийн Засгийн Үнэлгээг 2019 онд шинээр батлуулсан.

Хүснэгт-3

Төсөлд ашиглагдаж буй техник тоног төхөөрөмжийн жагсаалт			
№	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр	Үзүүлэлт	Тоо ширхэг
1	DAEWOO-280	0.8-1м ³	1
2	Ачигч ZL 30	3 м ³	1
3	НІТАСНІ 210W	1.3м ³	1
4	Бульдозер	2.5 м ³	1
5	Усны тэрэг, Зил 130	5 тн	1
6	Суудлын машин	5 хүн	1
7	НІТАСНІ 330W	1,0-1,2м ³	1
8	Автосамсомал	25 тн	3
			10

Хүснэгт-4

Ажиллах хүчний мэдээлэл		
№	Албан тушаал	Орон тоо
Инженер техникийн ажилтан		
1	Уурхайн дарга	1
2	Ерөнхий инженер, Маркшейдер	1
3	Ашиглалтын инженер	1
4	Байгаль орчны ажилтан	1
Үйлдвэрийн хэсэг		
1	Экскаваторын оператор	2
2	Автосамосвалын жолооч	2
4	Гагнуурчин, цахилгаанчин	1
5	Бульдозерын оператор, жолооч	1
6	Засварчин	1
7	Ачигчийн оператор	1
8	Үйлчлэгч	1
9	Тогооч	1
10	Манаач	1
11	Галч	1
12	Хүнд механизмын жолооч	3
Нийт дүн		16

1.2. Физик-Газарзүй, дэд бүтэц

1.2.1. Газарзүйн байрлал

Увс аймгийн Бөхмөрөн сумын нутаг нь цаг агаарын эрс тэс уур амьсгалтай, өндөрт өргөгдсөн уул, нуруу нам хотгор ээлжлэн тархсан газарзүйн байрлалтай

Бөхмөрөн сумын орчим эх газрын уур амьсгалтай, хур тунадас их, жилд дунджаар 123 -144 мм, үүний 85 -95 хувь нь дулааны улиралд (IY–X сар) унадаг, хамгийн их тунадас 7дугаар сард унаж жилийн нийлбэрийн 30% орчим хүрнэ. Өвөл харьцангуй хүйтэн, дунджаар 4-30 мм тунадас унадаг. Агаарын жилийн дундаж температур –3.70C хүрч 1-р сарын дундаж температур –49.60C, 7-р сарынх +38.40C хүрнэ. Агаарын температурын хамгийн их агуурс 88.00C байна.

Гүний усны түвшин нь геологийн ажлын явцад 45 метрээс доор илэрснийг тогтоосон. Тус уурхай нь 45 м хүртэл олборлолт явуулна гэж тооцоолсон.

Төсөл хэрэгжих орчмын газар нутаг нь ургамалжилтын байдлаар Евразийн хээрийн мужийн Ачит нуурын хотгорын цөлийн хээрийн тойрогт хамаарагдана. Энд Элдэв өвс-Үетэнд, Хялганат, Элдэв өвс-Улалж-Биелэг өвс-Үетэн, Агь-Хялганат, Ботуул-Агьд бүлгэм жилтэй бөгөөд *Stipa krylovii*, *Cleristogenes*

squarrosa, Agropyron cristatum, Carex duriuscula, Allium bidintatum, Ageria
cappularis* Artemisia frigida зэрэг олон төрөл зүйлийн ургамлын нөмрөгтэй.

Уурхайн нь Ачит нуурын хотгорын зүүн хойд хэсэгт Байрамын нурууны өвөрт
далайн түвшинээс 2050-2100 метрийн өндөрт уулархаг бүсэд байрлах бөгөөд
уулын хуурай хээрийн цайвар хүрэн хөрс зонхилон тархсанаараа онцлогтой.



Зураг-2 Хотгорын нүүрсний ордын газар доорх ус

Бөхмөрөн сум нь хойд талаараа Оросын Холбооны улс, зүүн талаараа Сагил,
Түргэн урд талаараа Ховд сум баруун талаараа Баянөлгий аймгийн Ногоон нуур
сумтай тус тус хиллэдэг. Аймгийн төв Улаангом сумаас 260км алслагдсан

589 айл өрхтэй 2290 хүн амтай, 3 багтай Гурван жигэртэй, Байшинт, Хар
алтат. Хүн амын гол хөдөлмөр мал аж ахуй хувиараа газар тариалан эрхлэн
амьдардаг. Нүүдлийн мал аж ахуйтай. Захиргаа, эмнэлэг, сургууль /8-11/,
цэцэрлэг, харилцаа холбоо зэрэг улсын төсвийн байгууллагууд ажиллахаас
гадна худалдаа үйлчилгээ, жижиг үйлдвэрлэл эрхэлдэг. Аймаг сумдын хооронд
авто тээвэр, харилцаа холбоо сайн хөгжсөн. Өндөр хүчдэлийн сүлжээнд
холбогдсон. Цаг уурын эрс тэрс уур амьсгалтай. Манай уурхай Хар алтат багт
оршдог.

1.3. Ордын геологийн тогтоц

Нүүрст хотгорын ордын судлагдсан районы геологийн тогтолцоо нь янз бүрийн насны бүтэцтэй чулуулгуудаас бүрдэнэ. Энэ нь ихэвчлэн төрмөлийн үед хамаарагдах боловч, Кембрийн түрүү чулуулаг бага хэмжээтэй байдаг. Мөн дунд төрмөлийн үеийн хурдас их биш тархсан ба шинэ төрмөлийн үеийн чулуулаг газар бүр тохиолдоно. Үүнд:

Кембрийн өмнөх үеийн хурдас Түргэн, Байрамын зүүн хойд хажуугаар баруун хойш чиглэсэн 20 км өргөн хлорлог гялтгануурт, цахиулаг занар, шохойн чулуу, Нейс, кварц зэрэг чулуулгуудаас тогтсон байна.

Палеозойн үеийн хурдас нүүрсний ордноос зүүн хойш Цагаан Шивээт , Байрам түргэний уулсын гол хэсгээс Ачит нуурын хотгорын хойд зах хүртэл тархсан 200м зузаан хөрсөн чулуу, шохойн чулуу, гантиг зэргээс тогтжээ.

Энэ чулуулаг нь олон янзын өнгөтэй, их уналтын өнцөг нь 70-80 хэм хүрнэ. Эдгээр чулуулаг итсилурын үед тогтжээ.

Девоны үеийн хурдас: Байрам болон Түргэний нурууны урд талаар тархсан нарийн ширхэгтэй элсэн чулуулаг дотроо үелсэн хар өнгийн цахиржсан занартайгаас гадна бага зэргийн гравелит хөрсөн чулуу орно. Үүний нийт зузаан нь 3.5км юм.

Мезовойн үед улаан өнгийн бутархай хөрсөн, элсэн чулуу хамаарагдана. Зузаан нь 200м .

Дөрөвдөгч галавын үед газрын гадаргын байдлаас болж жигд биш тархсан байна. Мөстөлт, усны нөлөөллөөс элэгдэж тогтсон хурдас уулын хормойд ил зузаан тогтож харагдана.

Гүний чулуулаг: Цолезойн үед хамаарагдана. Үүнд:

- а. Каледоны үеийн боржин
- б. Герциний үеийн диорит габбродиорит
- с. Герциний үеийн боржин гэж хуваагдана.

Герциний үеийн гүний чулуулаг ордын орчим өргөн тархсан гэж судлагдсан байна. Тус орд нь Хотгор нэртэй мульт структурын баруун захад далайн түвшинээс дээш 1880-1912 м өргөгдсөн нам өндөрлөгтэй уулсын бүсэд оршдог. Энд 2009 оноос ил аргаар олборлолт хийж эхэлсэн ба талбайн төв хэсэгт 170 х 100 м хэмжээтэй, 13 м гүнтэй уурхай бий болжээ.

Нүүрсний ордын талбайд дунд-дээд карбоны настай Улиастай формацын тунамал, галоцены настай аллювийн гаралтай сэвсгэр хурдас тус тус тархжээ. Дунд-дээд карбоны настай Улиастай формацын хурдас нь нүүрсний ордын зүүн

хагаст тархсан ба голдуу конгломерат, гарвелит, том-дунд ширхэгт элсэн чулуу болон нүүрсний давхаргаас бүрэлдэн тогтоно. Нүүрсний ордын хэмжээнд Улиастай формацын хурдас нь хойшоо суналтай, зүүн тийш 20-350 уналтай байна. Тус формацын зүсэлт нь саарал өнгөтэй конгломерат- гравелитын , нүүрс агуулсан цоохор өнгөтэй элсэн чулууны, саарал өнгөтэй гравелитлэг элсэн чулууны , нүүрсний давхарга бүхий алевроэлсэн чулууны зэрэг 4 багцаас бүрдэнэ

2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт-5

	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Давтамж Гүйцэтгэл
1. Агаарын чанар		
1	Агаарын чанарын шинжилгээ хийлгэх- 3 цэгт	2022 оны 06 болон 10 дугаар сард агаарын чанарын шинжилгээг хийлгэсэн
2	Машин техникийн засвар үйлчилгээг тогтмол хийлгэх.	2022 оны 4 сарын 27д техникийн улсын үзлэгт хамруулсан./ 6 техник /
3	Тоосжилт багасгах зорилгоор зам, тосгон орчмын ургамалан нөмрөг, тарьсан модоо хамгаалж услах	Усалгааг усны машинаар тогтмол усалсан.
4	Ажилчдыг тоосжилтоос хамгаалах зорилгоор хошуувч, маск, бээлийгээр хангах	Хувийн хамгаалах хэрэгсэлээр тогтмол ханган ажилласан
5	Ахуйн хог хаягдал болон бохирын цооногт ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж агаар бохирдохоос сэргийлэх	4 болон 8 сард халдваргүйжүүлэлтийн ажлыг хийсэн
2. Гадаргын ба газрын доорхи усны нөөц		
6	Төрийн байгуулагаар ус ашиглах дүгнэлт гаргуулан зөвшөөрөл авч гэрээ байгуулах	Увс аймгийн БОАЖГ-ын 2021 оны 03 сарын 13-ны адрийн 02 тоот дүгнэлтийг үндэслэн 2021 оны 04 сарын 01 өдөр ус ашиглах эрхийн бичгийг сунгасан.
7	Гүний худгийг битүүмжилж барилгажуулах	Гүний худгийн битүүмжлэлийг сайтар ханган ажилласан.
8	Усны урсац гуу жалга сувгийг цэвэрлэх	6, 9 сард их цэвэрлэгээний ажил зохион байгуулсан.
9	Газар доорхи усны химийн шинжилгээ хийлгэх,	2022 оны 06 болон 10 дугаар сард чанарын шинжилгээг хийлгэсэн
3. Хөрсөн бүрхэвч		
10	Хөрсний чанарын шинжилгээ хийлгэх	2022 оны 06 болон 10 дугаар сард хөрсний чанарын шинжилгээг хийлгэсэн
11	Зам талбайг тэмдэгжүүлэх, олон салаа зам гаргаж хөрсөн бүрхэвч хөндөхгүй байх	Тогтоосон замаар тээвэрийн хэрэгслийг явуулсан бөгөөд тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байршуулан ажилласан.
12	Шимт хөрсний овоолгыг технологийн дагуу хадгалах, шимт чанарыг сайжруулах	Энэ онд шинээр шимт хөрс хуулагүй бөгөөд хуучин овоолгыг ашиглаж эхлээгүй байна.
13	Шатах тослох материал асгарсан тухай бүрт цэвэрлэж байх	Уурхайн талбайд асгарсан шатах тослох материалаар бохирдсон хөрсийг тухай бүрт нь цэвэрлэж авсан.

4. Амьтны аймаг		
1 4	Хар сүүлт, аргал хонины шилжилт хөдөлгөөн төлөлтийн байдалд хяналт мониторинг сонгогдсон талбайд хийх /Талын харын хөдөө, Уушгийн улаан уул орчим/	Зэрлэг ан амьтан, малчдын мал услахад зориулан дүйцүүлэн хамгааллын талбайд худаг гарган тогтмол ажиллуулж байна.
5. Нийгэм эдийн засаг		
1 5	Малчдын унд ахуй, мал усалгаанд зориулж гаргасан Уушгийн улааны худгийг орон тооны хүнтэй болгож ажиллуулах /Энэ худаг нь аргаль хонь, хар сүүлтийн дүйцүүлэн хамгааллын сонгосон талбайд байгаа болно/	Дүйцүүлэн хамгааллын талбайд байрлах худгийг хариуцсан эзэнтэй болгон тогтмол цалинжуулан ажиллуулж байна.
1 6	/Тэр бум мод, үндэсний хөдөлгөөн, Увсын 2 живаа харгаа хөтөлбөрийн хүрээнд мод тарина/	Нийт 600 модыг /улиас/ уурхайн талбайн хөндөгдөөгүй хэсэгт тарьсан.
1 7	Хар алтат багийн бүх өрхийн нүүрсний хэрэгцээнд туслах	Нийт 210 айлд 400 тн нуурсний тусламж үзүүлсэн.

2.1. Агаарын чанар

Уурхайн орчмын тоосжилтыг дарах зорилгоор замын усалгааг усны машинаар тогтмол хийлээ. Мөн “Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд тарьсан модыг тогтмол усалж байна.



Зураг -3

Ажилчдыг нарийн ширхэгт тоосжилтонд өртөхөөс хамгаалан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулинд заасны дагуу бүх ажилчдыг тоосжилтоос хамгаалах маскаар тогтмол ханган ажиллаа.



Зураг -4 Уурхай дээр ажилчдад тогтмол тараагдсан ХХХ

Уурхайн үйл ажиллагаа жилийн 4 улиралд тогтмол үргэлжилдэг тул халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэн хавар дулаарах үе буюу халдварт өвчин ихээр дэгддэг 4 сар болон зуны халуун буюу 8 сард нийт 2 удаа уурхайн хогийн цэг болон бие засах газарт ариутгалын ажлыг хийсэн. Ариутгалд 3 кг хлорын шохой буюу ариутгалын бодис ашигласан.



Зураг -5

2.2. Гадаргын ба газрын доорхи усны нөөц

Уурхайн үйл ажиллагаа эхэлсэнээс хойш ус ашиглах дүгнэлт болон ус ашиглах эрхийн бичгийг тухай бүрт нь төрийн захиргааны төв байгуулагуудаас гаргуулан авч, ус ашиглаж ирсэн бөгөөд Увс аймгийн БОАЖГ-ын 2021 оны 03 сарын 13-ны өдрийн 02 тоот дүгнэлтийг үндэслэн 2021 оны 04 сарын 01 өдөр ус ашиглах эрхийн бичгийг 3 жилээр сунгуулаад ажиллаж байна.

Энэ онд уурхайн унд ахуй болон замын тоосжилт дарахад ашиглагдаж байгаа усыг хангах зорилгоор гаргасан уурхайн гүний худагт эвдрэл гэмтэл гараагүй тул худгийн шугам хоолой болон бүрэн бүтэн байдал хэвийн байна.

Уурхайн талбайд бүх ажилчдыг оролцуулан 6 болон 9 сард нийт 4 удаа их цэвэрлэгээний ажил зохион байгууллаа.

Газрын доорх усны чанарын шинжилгээг төлөвлөгөөний дагуу 6 болон 10 дугаар сард 2 удаа дээж аван, химийн ерөнхий шинжилгээг Увс аймгийн Ус Цаг Уур Орчны Хяналт Шинжилгээний Төвийн Байгаль орчны шинжилгээний лабораторид хийлгэсэн.

2.3. Хөрсөн бүрхэвч

Хөрсний чанарын шинжилгээг төлөвлөгөөний дагуу 6 болон 10 дугаар сард 2 цэгээс 2 удаа дээж аван, шинжилгээг Увс аймгийн Ус Цаг Уур Орчны Хяналт Шинжилгээний Төвийн Байгаль орчны шинжилгээний лабораторид хийлгэсэн.

Уурхайн талбайд 3 цэгт анхааруулах болон олон салаа замыг хориглосон тэмдэг шинээр байрлуулсан / зураг 2-3 /.



Зураг-6 Талбайд байршуулсан тэмдэглэгээ

Уурхайн талбайд байрлах шимт хөрсний овоолгыг стандартын дагуу хадгалж байгаа бөгөөд энэ жил хөрс хуулалтын ажил нэмж хийгээгүй болно.

Тос түлш болон тенхикийн шингэний асгаралтаас сэргийлэн уурхайн талбайд байрлах техникийн бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавин ажиллаа.

2.4. Амьтаны аймаг

Зэрлэг ан амьтан, малчдын малыг тогтмол ундаалах зорилгоор дүйцүүлэн хамгааллын талбайд гаргасан гүний худгийг тогтмол ажиллах нөхцөлөөр ханган ажиллаа (дэлгэрэнгүй мэдээллийг Дүйцүүлэн хамгааллын хэсгээс харна уу).

2.5. Нийгэм эдийн засаг

Дүйцүүлэн хамгааллын талбайд гаргасан гүний худгийг тогтмол ажиллах нөхцөлөөр ханган ажиллаа (дэлгэрэнгүй мэдээллийг Дүйцүүлэн хамгааллын хэсгээс харна уу).

3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт-6

	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Гүйцэтгэл
1	Улиас мод тарих	Уурхайн ойролцоох талбайд 600 ш улиас тарьсан.

Нүүрсний гүн 53 метрээс дээш байна. Карьерийн гүн 18 метрт хүрч байна . Доошоогоо 35 м нүүрс байна. Тийм учраас Техникийн болон, биологийн нөхөн сэргээлт хийх ажил төлөвлөгдөхгүй.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлигаар “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөн, Увсын 2 живаа харгаа хөтөлбөрийн хүрээнд 2022 онд 600ш улиасыг 0,6 га-д талбайд тусгай зөвшөөрлийн талбай дахь /нүүрсний нөөцийн хэсэгт үл хамаарах/ газар гуу жалга сайрд тарилаа.

Тарьсан модны усалгааг модны үрсэлгээг тухайн бүс нутагт дасан зохицох хүртэл буюу эхний жил усны машинаар зөөж услан ургуулж байна.



Зураг-7 Тарьсан модны ургалт болон усалгааны явц

4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

“Шүтэн Байгаль” ХХК-тай дүйцүүлэн хамгаалах ажлыг 5 жилийн төлөвлөгөөтэй гэрээ хийж 5 дэх жилдээ ажиллаж байна.

Энэ оны 8 сард зэрлэг амьтаддаа мониторинг судалгааны ажлыг Гүйн сай, Хөх сай, Шарилжит, Хурмашт зэрэг газруудаар явж ажиглалт хийсэн. 150 орчим аргал угалз ажиглагдсан ба чоно идсэн нэг угалз таарсан.



Зураг -8

2022 онд зэрлэг ан амьтад болон малчдад зориулан 1 худаг гарган, худгийг тогтмол ажиллуулах 1 хүнийг сонгон, уурхайгаас цалинжуулан ажиллуулж байна.

Дүйцүүлэн хамгааллын ажлын хүрээнд гаргасан тус худгийг 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Бөхмөрөн сумын Засаг даргын А/120 дугаартай захирамжаар байгуулагдсан 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг шалган хүлээн авч, акт үйлдсэн (*худаг хүлээлгэн өгсөн актыг хавсаргае*).



Зураг -9 Ашиглалтанд оруулсан худаг

5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Тус уурхайн орчны оршин суугчдын газар эзэмших, ашиглах эрх хөндөгдөхгүй, одоогийн байгаа ахуй амьжиргаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй тул нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох зайлшгүй зардал тооцох шаардлагагүй.

6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт-7

	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Гүйцэтгэл
1	Хөшөө чулуу хиргисүүрийн хашаа хамгаалалтыг сэргээж будна	Хашаа хамгаалалтыг цагаан өнгийн будагаар будан, засвар үйлчилгээ хийсэн

Манай уурхайн тусгай зөвшөөрлийн талбайд 2 ширхэг хөшөө чулуу, 6 хиргисүүрүүд байдаг. Энд байгаа хөшөө чулуу хиргисүүрүүдийг хашаалан хамгаалалтад авсан. 2011 оны 10 дугаар сарын 25-нд Улаанбаатараас Ш.У.А-ийн Археологийн хүрээлэнгийн секторын эрхлэгч, Соёлын өвийн хяналтын улсын байцаагч, доктор дээд профессор Ц.Төрбатаар судалгаа хийлгэж, улсын тооллогод бүртгүүлсэн болно. 2021 онд уурхайн урьд талын ирмэгт тэлэлт хийхийн тулд $x=5522450$ $y=341515$ координаттай хиргисүүрүүдийг ШУА-ийн Археологийн хүрээлэнд хүсэлт гаргаж гэрээ хийсэн тул аврах малталт хийлгэсэн.

Хөшөө чулуу хиргисүүрийн хашаа хамгаалалтыг будаж, сэргээх ажлыг 2022 оны 09 дүгээр сарын 22-ний өдөр хийж гүйцэтгэсэн.



Зураг -10 Хамгаалалтын хашааг сэргээн будсан байдал

7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Уурхайн үйл ажиллагааны явцад технологийн үйл ажиллагаанаас үүдэн ус нэвчих, гал түймэр гарах зэрэг эрсдэл гарч болзошгүй тул осол, эрсдлийг урьдчилан тооцох, дотоод хяналтыг байнга тавих, ослын үед яаралттай арга хэмжээ хэрэгжүүлэхэд шаардлагатай материал болон авран хамгаалах хэрэгслийн нөөцийг хангаж, ажиллагсдад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, сургалт явуулан, үйл ажиллагаанд дотоод хяналт тавин ажиллаа.

Хүснэгт-8

	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Гүйцэтгэл
1	Ажилчдыг ажлын хувцасаар хангах	Ажилчдыг ажлын хувцас хэрэгсэлээр тогтмол ханган ажилласан.
2	Ажилчдыг хөдөлмөр хамгаалах хэрэгслээр хангах	Ажилчдад шаардлагатай хөдөлмөр хамгааллын хэрэгслээр тогтмол ханган ажилласан.
3	Болзошгүй аваар ослын үед яаралттай хэрэглэх анхны тусламжийн багаж хэрэгсэл, эм тариаг бэлэн байлгах	Уурхайн талбайд анхны тусламжийн багаж хэрэгсэлийн нөөц хүрэлцээтэй байгаа эсэхэд тогтмол хяналт тавин ажилласан.
4	Аюулгүй ажиллагааны дүрэм журмын талаар тайлбарлаж таниулах сургалт зохион байгуулах	Ажилчдад Хөдөлмөр хамгааллын сургалтыг нэг удаа зохион байгуулан, өдөр бүр ажилд гарахын өмнө тухайн өдөр хийгдэх ажлаас хамааруулан хөдөлмөр хамгааллын зааварчилгаа өгч ажилласан.
5	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээ	2022 оны 4 сарын 14 өдөр 15 ажилчинг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан

Ажилчдыг ажлын хувцасаар хангах: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл эрүүл ахуйн тухай хуулийн дагуу уурхайн бүх ажилчид зориулалтын хувцасаар бүрэн хангагдсан.



Зураг -11 Ажилчдыг ажлын хувцасаар хангасан байдал

Ажилчдыг хөдөлмөр хамгаалах хэрэгслээр хангах: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл эрүүл ахуйн тухай хуулийн дагуу уурхайн бүх ажилчид зориулалтын хувийн хамгаалалх хэрэгсэлээр бүрэн хангагдсан.



Ажилчдад олгож байгаа нэмэлт хувийн хамгаалах хэрэгсэл

Болзошгүй аваар ослын үед яаралттай хэрэглэх анхны тусламжийн багаж хэрэгсэл, эм тариаг бэлэн байлгах: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл эрүүл ахуйн тухай хуулийн дагуу уурхайн талбай дээр яаралтай тусламжийн хэрэгсэлтэй хайрцагийг тогтмол цэнэглэн ажиллаж байна.



Зураг -12 Анхны тусламжийн хайрцаг

Анхны тусламжийн хэрэгсэлийн жагсаалт: 1 удаагийн боолт, ариун хөвөн, шархны наалт, боолт, хайч, спирттэй ариун хөвөн шаариг гэх мэт.

Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээ: 2022 оны 4 дүгээр сарын14д уурхайн бүх ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.

Аюулгүй ажиллагааны дүрэм журмын талаар тайлбарлаж таниулах сургалт зохион байгуулах: Бүх ажилчдад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл эрүүл ахуйн тухай хууль, дүрэм, стандарт, компанид мөрдөгдөж буй дүрмийн талаар ажилчдад мэдээлэл олгож, сургалтыг 2022.09.22д зохион байгууллаа.



Зураг -13 Сургалт зохион байгуулж байгаа байдал

8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт-9

	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Гүйцэтгэл
1	Хог хаягдлын гэрээ сумын ЗДТГ-тай байгуулах	Бөхмөрөн сумын ЗДТГын даргатай хог хаягдлын гэрээ байгуулсан
2	Ахуйн -Хог хаягдлыг гэрээт төвлөрсөн цэгт ачиж буулгах	Бөхмөрөн сумын хогийн цэгт буулгаж байна.
3	Ахуйн хог хаягдлаа ангилан тусад нь саванд хадгалж байна. /хуванцар шил лааз/	Сумынхаа дахивар бүтээгдхүүн авдаг цэгт тушааж байна.
4	Үйлдвэрийн - Үйлдвэрийн техникийн хог хаягдал	Уурхай талбай дээр хадгалж байна.

2020 оноос Бөхмөрөн сумын төвлөрсөн хогийн цэгийг хариуцан ажилладаг идэвхитэн байгаль хамгаалагчийг цалинжуулан ажиллуулж байна.

Энэ онд уурхайн үйл ажиллагаанаас гарсан 30 тн ахуйн хог хаягдлыг Бөхмөрөн сумын төвлөрсөн хогийн цэгт буулгасан.

Техникийн хог хаягдал болох тос түлш, техникийн шингэнээр бохирдсон арчих материал болон, тос түлшний сав зэргийг уурхайн талбай дээр хадгалж байна.

Хоёрдогч түүхий эдийг ахуйн хогноос тусд саванд ангилан хадгалж сумын дахивар бүтээгдхүүн авах цэгт тушаалаа.



Зураг -14 Хог ангилан түр хадгалах цэг

9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Хүснэгт-10

	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Давтамж Гүйцэтгэл
1. Агаар		
1	NO ₂ , SO ₂ , CO ₂	
2	Тоосжилт-	
2. Хөрс		
3	Макро, микро элемент	
4	Нефтийн бүтээгдэхүүний үзүүлэлт	
3. Гадаргын болон гүний ус		
5	Ундны усны чанарын шинжилгээ	

9.1 Агаарын чанарын шинжилгээ

Төлөвлөөний дагуу тайлант онд 2 удаа NO₂, SO₂, CO₂ шинжилгээг хийлгэсэн.

Хүснэгт-11

№	Үзүүлэлт	нэгж	Кемп	Карьер	MNS4585:2016	
1	Хүхэрлэг хий-	мг/м ³	0.005	0.006	0.450	
2	Азотын давхар исэл	мг/м ³	0.052	0.152	0.200	
3	Тоос	PM10	мг/м ³	0.008	0.005	0.100
4		PM2.5	мг/м ³	0.004	0.004	0.050
5		Нийт	мг/м ³	0.010	0.008	0.500

Шинжилгээний үр дүнг **MNS4585:2016** стандарттай харьцуулахад стандартын хүлцэх хэмжээнээс давсан үзүүлэлт байхгүй байна.

9.2 Хөрсний шинжилгээ

Төлөвлөөний дагуу тайлант онд 2 удаа химийн ерөнхий шинжилгээг хийлгэсэн.

Хүснэгт-12

№	Үзүүлэлт	нэгж	Кемп	Карьер
1	Орчин	мг/кг	7.74	7.57
2	Давсжилт-ЕС		342	302
3	Чийг	%	4.15	3.56
4	Ялзмаг		3.1	2.6
5	Аммиак	мг/кг	50.0	40.2
6	Нитрат	мг/кг	14.1	8.1
7	Фосфат	мг/кг	1.4	1.2
8	Хөрсөн дэх нефтийн бүтээгдэхүүн	мг/кг	3.2	2.3

9.3 Гадаргын болон гүний усны шинжилгээ

Төлөвлөөний дагуу тайлант онд 2 удаа химийн ерөнхий шинжилгээг хийлгэсэн.

Хүснэгт-13

№	Үзүүлэлт	нэгж	Гүний худаг	MNS 900:2018
1	Орчин		7.87	6.5-8.5
2	Умбуур бодис	мг/л	1.0	
3	Цахилгаан дамжуулан чанар		932	1000
4	Исэлдэх чанар	мг/л	4.1	
5	Аммони		0.07	1.5
6	Нитрит		0.001	1.0
7	Нитрат		2.24	50.0
8	Сульфат		323.6	500.0
9	Фосфат		0.006	3.5
10	Төмөр		-	0.3
11	Фтор		1.56	0.7-1.5
12	Хлор		10.6	350.0
13	Магни		46.7	30.0
14	Хатуулаг		8.03	7
15	Натри+Кали		59.2	200
16	Гидрокарбонат		205	
17	Кальци		84	100
18	Цахиур	12.4		

Шинжилгээний үр дүнг **MNS 900:2018** стандарттай харьцуулахад хэвийн байна.

10. Аймаг, сумын Засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ

2022 онд аймаг сумын ЗДТГ-аас албан шаардлага ирээгүй болно.

11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт-14

	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Давтамж Гүйцэтгэл
1	Ус, хог хаягдал, орчны шинжилгээнүүдийн гэрээнүүдийг холбогдох байгууллагуудтай хийж ажиллах.	Ус ашиглах гэрээг 2021 онд 3 жилийн хугацаатай байгуулсан. Орчны хяналт шинжилгээ хийлгэх гэрээг УЦУОХШТөвтэй байгуулсан. 2019.10 сард 2 жилээр байгуулсан байсан 2022.10.26д шинэчлэн байгууллаа.
2	Цаг үеийн байдал орон нутагт хүндэрсэн тохиолдолд сум аймгийн ЗДТГтай хамтран ажиллах	2022 онд Бөхмөрөн сумын гудамж талбайн цэцэрлэгжүүлэгч иргэн, төвлөрсөн хогийн цэгийн ажилтан идэвхитэн байгаль хамгаалагчийг цалинжууллаа. Мөн Хар алтат багийн 210 өрхөд 400тн нүүрс өглөө.
3	Түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, гал түймрийг унтраах багаж хэрэгслийг бэлтгэн байнгын бэлэн байдалд байлгах	Гал түймрийг унтраах багаж хэрэгслийн нөөцийг байнга хянаж бэлэн байлгаж байна
4	Байгаль орчин байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл, аюулгүй ажиллагаанаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтыг жилд 2 удаа тогтмол хийнэ.	2022оны 9 сарын 22 д аюулгүй ажиллагааны сургалтыг зохион байгуулсан
5	Байгаль орчныг хамгаалах талаар хийсэн ажлын тайланг 1 удаа орон нутгийн засаг захиргаанд тайлагнах, мэдээллийн самбараар олон нийтэд мэдээллэнэ.	2022 оны 11 сарын 01-нд мэдээллэсэн.
6	БОМТөлөвлөгөөний биелэлтийн тайланг Увс аймгийн БОАЖГазарт хүргүүлж дүгнүүлэх	2022 оны 11 сарын 01-нд хүргүүлсэн.
7	БОАЖЯ-ХБОБНУГазарт дүгнүүлсэн тайланг дараа оны төлөвлөгөөний хамт хүргүүлэх	Тайлан дүгнүүлсэний дараа 2022 оны 12 сарын 01 –д хүргүүлнэ.

1. Ус, хог хаягдал, орчны шинжилгээнүүдийн гэрээнүүдийг холбогдох байгууллагуудтай хийж ажиллах.

Бөхмөрөн сумын Засаг Даргын Тамгын Газартай хог хаягдал, Увс аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газартай усны гэрээ, дүгнэлт, Ус цаг уур орчны шинжилгээний газартай ус, агаар, хөрс орчны бохирдлын шинжилгээний гэрээг байгуулан ажилласан. Гэрээнүүдийн хуулбарыг хавсаралтаас үзнэ үү.

2. Цаг үеийн байдал орон нутагт хүндэрсэн тохиолдолд сум аймгийн ЗДТГтай хамтран ажиллах.

Энэ онд цаг үеийн байдал тайван байсан тул сумтай байгуулсан гэрээнүүдийн дагуу ажлаа гүйцэтгэсэн болно. Бөхмөрөн сумын гудамж талбайн

цэцэрлэгжүүлэгч иргэнийг 2021оноос, төвлөрсөн хогийн цэгийн ажилтан идэвхитэн байгаль хамгаалагчийг 2019 оноос тус тус цалинжуулж байна. Хар алтат багийн 210 өрхөд жил бүр 400тонн нүүрсний дэмжлэг үзүүлж байна.

3. Түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, гал түймрийг унтраах багаж хэрэгсэлийг бэлтгэн байнгын бэлэн байдалд байлгах.

Увс аймгийн БОАЖГазар, МХгазар, Улаангом сумын ЗДТГазар, УЦУОШГазар, Увс нуур Тэсийн голын сав газрын захиргаа зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж мэргэжил аргазүйн зөвлөгөө аван ажиллаа. Увс аймгийн БОАЖГазар, Бөхмөрөн сумын ЗДТГазарт үйл ажиллагаагаа тайлагнан ажиллаж байна.

4. Байгаль орчин байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл, аюулгүй ажиллагаанаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтыг жилд тогтмол хийнэ.

Байгаль орчин , гал түймэр болон байгалийн гамшгийн гэнэтийн аюулт үзэгдэлээс урьдчилан сэргийлэх, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл эрүүл ахуйн тухай хууль, дүрэм, стандарт, компанид мөрдөгдөж буй дүрмийн талаар нийт ажилчдын дунд 9 дүгээр сарын 22д сургалт зохион байгуулсан. Сургалтанд бүх ажилчид хамрагдсан бөгөөд талбай хариуцсан инженер тараах материал тарааж өгсөн.

6. Байгаль орчныг хамгаалах талаар хийсэн ажлын тайланг 1 удаа орон нутгийн засаг захиргаанд тайлагнах, мэдээллийн самбараар олон нийтэд мэдээллэнэ.

Байгаль орчин хамгаалах ажлын тайланг 2022 оны 11 сарын 01 нд Бөхмөрөн сумын ЗДТГазарт тайлагнан, мэдээллийн самбараар олон нийтэд мэдээлэл хийсэн.

7. БОМТөлөвлөгөөний биелэлтийн тайланг Увс аймгийн БОАЖГазарт хүргүүлж дүгнүүлэх

2022 оны 11 сарын 01 –нд хүргүүлэв.

8. БОАЖЯ-ХБОБНУГазарт дүгнүүлсэн тайланг дараа оны төлөвлөгөөний хамт хүргүүлэх

Тайлан дүгнүүлсэний дараа 2022 оны 12 сарын 01 –д хүргүүлнэ

**12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө,
төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин
суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт**

Хүснэгт 15

БОМТөлөвлөөний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацаа /он, сар /	Зохион байгуулах газар
Бөхмөрөн сумын ЗДТГазар	Хэвлэмэл	Хэрэгжилтийг хангах, хэрэгжилтийг хянуулах	2022.11	Уурхай
Увс аймгийн БОАЖГазар	Хэвлэмэл		2022.11	Уурхай
БОАЖЯ-ХБОБНУГазар	Хэвлэмэл		2022.11	Уурхай

Хавсралт

Хавсралтын баримтын жагсаалт

1. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
2. Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн хуулбар
3. Байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээний хуулбар
4. Ус ашиглуулах дүгнэлтийн хуулбар
5. Ус ашиглах гэрээний хуулбар
6. Ус ашиглах эрхийн бичгийн хуулбар
7. Хог хаягдлын гэрээний хуулбар
8. Ус цаг уур орчны шинжилгээний төвтэй байгуулсан гэрээний хуулбар
9. Хөрсний шинжилгээний дүнгийн хуулбар
10. Агаарын шинжилгээний дүнгийн хуулбар
11. Усны шинжилгээний дүнгийн хуулбар
12. Бөхмөрөн сумын Засаг даргын захирамжийн хуулбар
13. Дүйцүүлэн хамгааллын талбайн худаг хүлээн авсан актны хуулбар
14. Усны төлбөр төлсөн баримтын хуулбар